



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction

ТӨРӨЛ БҮРИЙН УРГАМЛЫН ЗУТАН, ЗООДОЙ БЭЛТГЭХ

Ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдийг хольж багсран шахмал тэжээл бэлтгэхийг зоодой хэмээн нэрлэдэг. Өвөл, хаврын улиралд төрөл бүрийн ургамлаар бэлтгэсэн зоодой, зутанг ядарч доройтсон малд болон төл малд өгнө.



Таана, хөмүүлийн зоодой: Зоодойг хольцтой ба хольцгүй хийж болно. 6-р сарын 15-наас 8-р сарын 20 хүртэл хугацаанд таана, хөмүүлийг түүж аваад хэрчих буюу машиндаж өөрийн шүүсэнд нь барьж зоодойлно. Эсвэл 2 шанага таананд дунд шаазангаар гурил буюу хивэг, эсвэл аарц хоолны халбагаар 5-6 удаа нунтаг давс буюу хужир хийж 20-50 граммын хэмжээтэй таана хөмүүлийн зоодойг хуурайгаар нь буюу халуун усанд хийж хандалж өгөхөөс гадна өвс, сүрэл, бусад тэжээлтэй хольж үнэртүүлж өгвөл мал тэжээлд амархан орно. Зоодойг хурга, ишгэнд өдөрт 1-2 ширхэг /30-60гр/ өгөх буюу буцалгасан 1 литр усанд 1 ширхгийг хандлан төлд 20-30 гр, бод малд 200-300 гр-ыг өдөрт 1 удаа өгнө. Таанын ногоон зоодой 33.3 хувь, аарцтай хольсон нь 37.7 хувийн уурагтай байна.

Таана, эрдсийн зоодой: Таана, агь, хөмүүл, хужир, давсыг будааны гурилтай адил хэмжээгээр найруулж зоодойлно. Зоодойг малд өгөхдөө нунтаглаад өдөрт хоолны халбагаар бод малд 2 удаа, бог малд 1 удаа тогтмол өгнө.

Шар будаа, хивэгний зоодой: Нунтагласан шар будаа 15 хувь, хонины сүүл 30 хувь, хуурсан хивэг 20 хувь, буцалсан ус 30 хувь, хужир, давс 5 хувийг хольж багсраад 30-40 граммын зоодой хийж төл ядарч доройтсон хонь, ямаанд өдөрт 3 удаа нэг ширхгээр өгнө.

Сэвстэй зоодой: Сэвс нь хивэгч малын гүзээнд байдаг нян, шаахай хэмээх бүдүүлэг бичил биетнээр боловсорсоноос гадна шүлсэнд дэвтэж гүзээний нянгийн уургаар баяжсан тэжээл юм. Сэвсийг буцалгаж ариутгаад давс, хужиртай хольж зоодойлон хатаана. Бод малд өдөрт 1-2 кг, бог малд 500-600 гр идүүлнэ.

Эрдсийн зоодой: Шатааж нунтагласан ясны үнс, гурил, нунтаг давс, нунтаг хужираас тус бүр 2.5 кг хийж сайтар холино. Энэ холимогийг нэг килограмм тутамд 250 гр ус ноогдохоор бодож усаар зуураад зоодойлно. Зоодойг төл малд долоолгоно.

Зутан бэлтгэх, хэрэглэх аргууд: Төрөл бүрийн нунтагласан үр тариа, гурил, хивэг зэргийг ашиглан зутан бэлтгэж малын тэжээлд ашиглах боломжтой.

Гурилын зутан: Турж доройтсон мал, төлийг гурилан зутангаар тэжээхэд сайн нөлөө үзүүлнэ. Гурилын зутан бэлтгэхдээ 5-6 литр ус буюу шөлөнд 300-500г гурил самарч буцалгана. Бэлтгэсэн зутанг бод малд 1-2 литр, бог малд 300-500 граммыг өглөө мал бэлчээхийн өмнө уулгах нь илүү үр дүнтэй. **Хошуу будааны зутан /овьёосны/:** Энэ нь төлийн гэдэс ходоодны ажиллагааг сайжруулахаас гадна өвчилсөн ба ядарч доройтсон төлийг түргэн тэнхрүүлж махлуулдаг. Зутан бэлтгэхдээ сайн чанарын овьёосыг дутуу хуурч тээрэмдэж гурил болгоно. Нэг кг овьёосны гурил дээр 2.5 литр буцалсан ус хийж сайтар хутгаад хөргөнө. Дараа нь шингэнийг шүүж литр тутамд 5 г хоолны давс хийж зутан болтол буцалгаад 30-35 градусын бүлээн болгож төлд өгнө. Бэлтгэсэн зутанг хонуулалгүй өдөрт нь өгөх хэрэгтэй. Халуун газар хонуулбал амархан исэж муудна. Зутан бэлтгээд гарсан өтгөн хэсгээр нь тамир тэнхээ муутай мал, төллөсөн малд өгнө.

Хошуу будааны зутангаар төл мал тэжээх норм /г/

Тэжээлийн төрөл, хэмжээ	Тэжээх төл малын нас /хоногоор/			
	12-15	16-18	19-21	22-24
Хошуу будааны зутан, г	50-80	200	300	400

Боловсруулсан: МAAЭШХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан Л.Алтанцэцэг